СОГООТЫН 1 ДҮГЭЭР БАГИЙН ЗАСАГ ДАРГА Х.ЦЭРЭНДОЛГОРЫН 2024 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

2024 оны 12 дүгээр сарын 21 Арвайхээр сум

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин биелэлт | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Дээд шатны байгууллагуудаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах”** | | | | | | | |
| 1. | **1.1**Тогтоол шийдвэрийг хяналтад авч хэрэгжүүлэх. | Хяналтад авсан заалтын хэрэгжилтийн хувиар | 50% | 100% | “Хүүхэд хамгаалалын бодлого” аймгийн тогтоол, Аюулгүй иргэн Амар тайван Өвөрхангай“ дэд хөтөлбөр, сумын Цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтот жилийн тогтоол шийдвэрийг хяналтад аван хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 01-12 сар | 100 |
| | **1.2** “Нээлттэй Өвөрхангай” хөтөлбөрийг сурталчлах. Улаанбаатар, Эрдэнэт, Дархан болон бусад хотуудаас шилжин ирж байгаа өрхийн хүүхдүүдийг хамран сурах тойргийн ЕБС, СӨБ-д хамруулах. | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 1 | 2 | “Нээлттэй Өвөрхангай” хөтөлбөрийг сурталчлан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Одоогоор төвлөрсөн хотуудаас шилжиж ирсэн 4 өрхийн 10 иргэн байна. | 01-12 сар | 100 |
| | | Хүсэлтийн шийдвэрлэлтийнхувиар | 50% | 100% | Төвлөрсөн хотуудаас шилжиж ирсэн 4 өрхийн 10 иргэний нэг иргэн ажилд орсон, нэг иргэн ахмад настан, 2 хүүхэд цэцэрлэгт байна. | 06-12 сар | 100 |

07

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **1.2.1** Сул ажлын байрны зарыг иргэдэд нээлттэй хүртээмжтэй хэлбэрээр хүргэх. | Иргэдэд хүргэсэн зарын тоогоор | 2 | 5 | Хөдөлмөр халамж үйлчилгээний газар болон хувийн хэвшил аж ахуй нэгжээс ирсэн түр болон бүр ажлын байрны зарыг Согоот багийнхаа фэсбүүк, хэсгийн ахлагчийн болон бусад груп чатуудад нээлттэй оруулж иргэдийг холбон зуучилж ажилладаг. Үүний үр дүнд түр ажилд 15, байнгын ажилд 4 иргэн хамрагдаад байна. | 01-12 сар | 100 |
| | **1.3**“Цахим шилжилтийг эрчимжүүлэх” зорилтод жилийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 50% | 100% | Сумын “Цахим шилжилтийг эрчимжүүлэх” зорилтот жилийн хүрээнд төлөвлөгөөг гарган ажиллаж байна.<br>Иргэд www.e-mongolia.mn веб портал болон “E-Mongolia” гар утасны аппликейшн ашиглаж аль нэг төрийн байгууллагыг зорьж очилгүйгээр, өөрт хэрэгтэй төрийн үйлчилгээг гэрээсээ эсвэл ажил дээрээсээ ямар ч цаг үед авч болох боломжийг "E-Mongolia" олгож байх талаар иргэдэд мэдээллэн ажиллаж байна.<br>Багт E-Mongolia цахим системийг ашиглан 36 иргэн цэргийн бүртгэлээр бүртгүүлсэн, 25 иргэн EMongolia цахим системийг ашиглан ОНХСанд цахимаар саналаа өгсөн байна.<br>Малчдад сургалт зохион байгуулж багийн 23 малчин оролцож Эрсдэлгүй Өвөрхангай апп-ыг сурталчилж, What 3 words апп-ыг сурталчлан иргэдэд ашиглалтыг заан өгч ажилласан. Багийн 23 иргэн What 3 words апп-ыг сурталчлах гар утсанд суулгаж өгсөн. | 01-12 сар | 100 |
| | **1.4.**“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөнийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, хэрэгжилтийг хангаан ажиллах. | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 1 | 2 | Хашаандаа жимсний мод тарих, хүлэмжийн аж ахуй эрхлэх зөвлөмжийг багийн иргэнээр 1удаа хийлгэсэн. Хэсгийн ахлагчид хашаандаа мод тарьсан айл өрхийн тохьжилттой танилцаж хариуцсан гудамжны айл өрхөд сурталчилах ажлыг зохион байгуулсан. | 01-12 сар | 100 |
| | | Ногоон байгууламж нэмэгдүүлсэн өрхийн | 20 | 50 | Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГазраас модны нүхээ ухсан өрхүүдэд үнэгүй мод суулгах арга хэмжээ зохион байгуулж байгаатай холбогдуулан шаардлага | 01-12 сар | 90 |

08

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тоогоор | | | хангасан 10 өрхөд 10 ш улиас, 5 агч тариулсан. Мөн багийн 25 өрх шинэс, үхрийн нүд, чацарган, бургас зэрэг 30 ш мод хашаандаа тариалсан. | | |
| | | Сургалт, мэдээлэлд хамрагдсан өрхийн тоогоор | 30 | 50 | Хэсгийн ахлагч /15/ нарыг багийн тохьжилт сайтай хашаатай өрхөөр оруулж туршлага судалуулж хариуцсан гудамжны айл өрхөд сурталчилах ажлыг хийсэн.<br>Хашаандаа жимсний мод тарих, хүлэмжийн аж ахуй эрхлэх арга зүйн сургалтыг багийн иргэнээр 1 удаа хийж 25 иргэн хамрагдсан. | 01-12 сар | 100 |
| | **1.5** Багийн хэмжээнд улирал бүр нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж нэгдсэн хог тээврийн хуваарийн дагуу хог ачилтад хяналт тавих | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 2 | 4 | Нийтийн их цэвэрлэгээг багийн нутаг дэвсгэрт 4 удаа зохион байгуулж 30 тн хог цэвэрлүүлж хогийн цэгт хүргүүлсэн. Давхардсан тоогоор 60 гаруй иргэн оролцсон. Цэвэрлэгээнд хүнс тэжээлийн дэмжлэг авдаг иргэд идэвхитэй оролцсон. | 01-12 са | 100 |
| | **1.6** Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлыг дэмжиж, хамтран ажиллах. | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 1 | 2 | Агаар бохирдуулагч эх үүсвэрийн мэдээллийн санд 3-15 квт хүчин чадалтай 859 өрх, усан халаалтын 15-100 квт чадалтай зуухтай 2өрх, нийт 861 өрхийн судалгааг өгөгдсөн маяг загварын дагуу гарган баяжилт хийн программд шивж оруулсан.<br>Багт иргэдийн санал хүсэлтээр цэвэр бохирын шугамын төсөл орж ирж хийгдэж байна.<br>Орчны бохирдол, эрүүл ахуйн талаар мэдээлэлийг иргэдэд тухай бүрт хүргэж ажилладаг. Давхардсан тоогоор 50 иргэнд мэдээлэл хүргэсэн.<br>Иргэд өөрсдийн санаачлагаар халаалтаа нэгтгэх, бохироо соруулах арга хэмжээнүүдийг авч байна. Хамрагдсан өрх-18 | 01-12 сар | 100 |
| | | Сайжруулсан шахмал түлшийг хэрэглээнд нэвтрүүлсэн | 5% | 10% | Сайжруулсан шахмал түлшийг 2 цэгт борлуулж байгаа бөгөөд нийт өрхийн 10 хувь нь буюу 80 орчим өрх хэрэглээндээ нэвтрүүлж Баянтээг ХХК-с нийлүүлсэн тоо хэмжээгээр хэрэглээндээ нэвтрүүлж байгаад 2 дугаар сард үйлдвэрлэсэн нөөц дууссан. | 01-12 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | өрхийн хувиар | | | Байшинг халаахдаа муу үнс их гардаг гэсэн гомдол ирсэн. | | |
| | | Шинээр эко, болон сайжруулсан нойл, муу усны цооногтой болсон өрхийн тоогоор | 5 | 10 | Шинээр эко, болон сайжруулсан нойл, муу усны цооногтой болох төсөл хэрэгжиж 20 өрх санал өгч мөнгөө шилжүүлсэн боловч гүйцэтгэгч компани нь ажлаа хийгээгүй, хувиараа 5 өрх, төслөөр 3 өрх нийт 8 өрх эко нольтой болсон. | 03-12 сар | 90 |
| | **1.7**Малчдын“Аравтын бүлэг”-ийг чадавхжуулах ажил зохион байгуулах, бүлгийн тоог нэмэгдүүлэх. | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 1 | 1 | 1.Монгол улсын Засгийн газраас улс орон даяар хэрэгжүүлж байгаа Шинэ хоршоо хөдөлгөөний сургагч багш орон нутагт ирж ажиллаж байгаатай холбогдуулан багийн 15 малчин өрхэд хоршооны тухай мэдээлэл ойлголт өгүүлж ажилласан. 2.Аймгийн Хөдөө АА-н газраас “Шинэ хоршоо” хөдөлгөөн арга хэмжээг зохион байгуулж хоршооны 2 малчин оролцуулсан. | 01-12 сар | 100 |
| | | Чадавхжсан Аравтын бүлгийн тоогоор | 1 | 1 | Багийн малчин оролцсон 5 хоршоо байгуулж гэрчилгээгээ авсан байна. | 01-12 сар | 100 |
| | **1.8** Өвөлжилтийн бэлтгэл хангуулах төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулах. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | - | 100% | Өвөлжилтийн бэлтгэл хангуулах төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтэнд хяналт тавьж ажилалаа. | 08-10 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **1.9**Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон бичил бизнес эрхлэгчдийг төсөл хөтөлбөрийн сургалтад хамруулах, зуулчлах. | Төсөл хөтөлбөрт зуулчилж, сургалтад хамруулсан тоогоор | 5 | 10 | Аймгийн ХХҮГазар болон ТББайгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдэд шаардлага хангасан иргэдийг уламжилан ажилладаг.<br>ДЗОУБайгууллагаас зорилтот өрх 7 малчинд хүнс тэжээлийн дэмжлэг, УЗХорооноос 1 малчинд мөнгөн тусламж үзүүлсэн малчдад өрхийн бэлэн байдлын сургалт мэдээлэлийг өгч ажиллаа.<br>Нийтийг хамарсан ажилд 15 иргэн, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 1 иргэн, ахмад настны зөвлөн туслах үйлчилгээнд 1 ахмад, хоршоо байгуулж 2малчин зээл авсан. | 01-12 сар | 100 |
| **Зорилт 2. "Хууль болон бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах"** | | | | | | | |
| 2. | **2.1.** Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчилж, хэрэгжилтийг хангаж ажиллах. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 100% | 100% | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 1-р улиралдаа шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Монгол улсын Засгийн газрын 2017 оны 67, 2011 оны 339, 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургууль 2024 оны 04 дугаар сарын 25 ний 16.00 цагт ЕБ-ын 5-р сургуулийн гаднах талбайд цугларч дадлага сургуулалтад багийн 71 иргэн, ЕБ-ын 5 дугаар сургуулийн 25 багш, ажилчид 600 гаруй сурагч, 26 авто машин тээврийн хэрэгсэл оролцож, аймгийн Онцгой байдлын газрын албан хаагчдын гамшгийн үеийн бэлэн байдлын талаарх сургалт мэдээллийг өгүүлж, арга хэмжээний мэдээг Аймгийн ОБГазарт хүргүүлэн ажилласан. | 01-12 сар | 100 |
| | **2.2.**Өвөрхангай аймгийн анхан шатны Улаан Загалмай хороотой хамтран ажиллах. | Шинээр сайн дурын идэвхтэн гишүүн элсүүлсэн иргэний тоогоор | 5 | 10 | Шинээр сайн дурын идэвхтэн гишүүнд 1 малчин Улаан Загалмайн хорооны онцгой гишүүнээр, 4 малчин гишүүнээр элсүүлсэн. Нийт-5 | 01-12 сар | 50 |
| | **2.3.**Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ | Гэрээний хэрэгжилтийн | 50% | 100% | Уянсэтгэл өрхийн эрүүл мэндийн төв сумын ЗДТГазартай хамтран ажиллах гэрээ байгуулж | 01-12 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулж, хамтран ажиллах. | хувиар | | | хэрэгжилтийг хангаж хамтран ажиллаж байна. | | |
| | | Үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэний хувиар | 25% | 50% | Эрт илэрүүлэгийн үзлэгт багийн иргэдийг хамруулах талаар анхаарч ажиллаж байна. Нөхөн үржихүйн 15-49 насны эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх эхо үзлэгт-215, артерийн гипертензийн эрт илэрүүлэг-615,умайн хүзүүний эсийн шинжилгээнд-132, хөхний хавдрын эрт илэрүүлэг-534, чихрийн шижингий илэрүүлэгт эрэгтэй-142,эмэгтэй 409,элэгний хавдрын илэрүүлэг В С вирус-122 иргэн тус тус хамрагдсан. Үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэний тоо 2169, хувь-70 | 01-12 сар | 100 |
| | **2.4.**Мал эмнэлгийн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулах, хамтран ажиллах. | Гэрээний хэрэгжилтийн хувиар | 50% | 75% | Малын эмчтэй хамтран ажиллах гэрээ байгуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна. Жилийн эцсийн мал тооллогын дүн гарсны дараа малын эмчид бүх малын тоог жагсаалтаар гарган өгч эмнэлэгийн үйлчилгээнд хамруулах талаар анхаарч ажиллаа. Мал эрүүлжүүлэх, халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх зорилготой тарилга туулга хуваарийн дагуу хийгдсэн. | 01-12 сар | 100 |
| | **2.5.** Хагас жил болон жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулж, хуулийн хугацаанд программд оруулах. | Мэдээг мал тооллогын программд алдаагүй үнэн зөв оруулсан хувиар | 50% | 100% | Улсын хэмжээнд зохион байгуулагддаг жилийн эцэс болон хагас жилийн түүвэр тооллогыг хийж төл бойжилтын мэдээ, төлийн болон том малын зүй бус хорогдлын мэдээг авч ажиллаа. Мэдээг мал тооллогын программд алдаагүй үнэн зөв оруулаж холбогдох А данс, илтгэх хуудсыг сумын мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн. | 01-12 сар | 100 |
| | **2.6.**“Багийн хамтарсан баг”-ийн үйл ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөөг батлах, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 50% | 100% | Хүүхэд хамгааллын хамтарсан багийн төлөвлөгөөг батлан хяналт тавьж арга зүйгээр ханган ажиллаа. 2 кес дээр ажиллаж 2-ийг нь хаасан. | 01-12 сар | 100 |
| | **2.7.**Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан | Зохион байгуулсан | 1 | 3 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг гарган багийн Засаг даргаар батлуулан | 01-12 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлэх төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих. | арга хэмжээний тоогоор | | | хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Цагдаагаас 14 албан мэдэгдэл ирсэнийг мэдэгдлийн дагуу ажил зохион байгуулж хугацаанд нь хариуг өгсөн, багт гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдээ үл хайхрах, архины хамаарал бүхий гэмт хэрэгт кес нээж ажиллалаа. 9,12-р багтай хамтарч 2 сургалт хийсэн. Багийн цагдаа, аймгийн нийгмийн бодлогын мэргэжилтэнтэй хамтран электрон тамхи зардаг дэлгүүрүүдээр хяналт шалгалт хийсэн. хүнсний дэлгүүр, үйлчилгээний газруудад аймаг, сумын Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин, мэдээ сурталчилгаа хийн ажиллаж хэвшсэн. | | |
| | **2.8.**Хөдөө аж ахуйн ХАА-1, ХАА-2, ХАА-3, ХАА-5, ХАА-6, ХАА-7, ХАА-8, ХАА-9, ХАА-10 мэдээнүүдийг хугацаанд нь үнэн зөв гаргаж, нэгтгүүлэх. | Мэдээний тоо | 30 | 47 | Хөдөө аж ахуйн ХАА-1, ХАА-2, ХАА-3, ХАА-5, ХАА-6, ХАА-7, ХАА-8, ХАА-9, ХАА-10 мэдээнүүдийг цаг тухай бүрт хугацаанд нь үнэн зөв гаргаж, судалгааг программд бүрэн шивж ажилладаг. Мал тооллогын дүнг 2 удаа мал төллөлт, төл бойжилтийн мэдээ 8 удаа том малын зүй бусын хорогдолын мэдээг 8 удаа хүнсний ногоо, жимс жимсгэний тариалсан талбайн мэдээ 3, ХАА-7 А,Б тус бүр 1 удаа, ХАА-8 3 удаа ХАА-9 А,Б –г тус бүр 1 удаа, ашиглалтанд оруулсан орон сууцны мэдээ 1 удаа тус тус гаргаж холбогдох мэргэжилтэнд өгсөн. | 01-12 сар | 100 |
| | **2.9.** Багийн зохион байгуулагч, нийгмийн ажилтныг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах. | Өгсөн үүрэг даалгавар, арга зүйн зөвлөмжийн биелэлтийн хувиар | 50% | 100% | Багийн зохион байгуулагч, нийгмийн ажилтныг үүрэг даалгавар өгч удирдлага, арга зүйгээр хангаж ажиллаж байна. Өгсөн үүрэг даалгаварыг цаг тухайд нь биелүүлж хэвшсэн, тухайн ажлыг хийхэд нь арга зүйгээр хангаж ажиллаж байна. | 01-12 сар | 100 |
| | **2.10.**БИНХ-ыг зохион байгуулах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах, | Зохион байгуулсан хурлын тоогоор | 2 | 4 | Багийн ИНХурал 3 удаа зохион байгуулсан. Хурлаас гарсан шийдвэрийг дээд шатанд уламжилж авсан арга хэмжээ, биелэлтийг дараагийн хуралд иргэдэд тайлганаж хэвшсэн. | 01-12 сар | 90 |
| | | Гарсан шийдвэрийн хэрэгжилтийн | 50% | 100% | Иргэдээс 11 төрлийн санал хүсэлт гарсан бөгөөд тэдгээр санал хүсэлтийг Арвайхээр сумын ИТХурал, Засаг дарга, түүний Тамгын газар, Хотын | 01-12 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | биелэлтийг тайлагнах. | хувиар | | | Захирагчийн алба болон холбогдох байгууллагад нь уламжилсан.<br>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хийгдэх арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг эрэмбэлэн санал хураaж жагсаав. Нийт 10 асуудал эрэмбэллээ. | | |
| **Зорилт 3. "Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх"** | | | | | | | |
| 3. | **3.1.**Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлэх, удирдлагыг тухай бүр үнэн зөв мэдээллээр хангах. | Үүрэг даалгаврын хэрэгжилт хувиар | 100% | 50% | Байгууллагын удирдлагаас өгсөн цаг хугацаатай үүрэг даалгаврыг тухай бүр нь хэрэгжүүлэн ажиллаж байна. Багийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тухай бүр удирдлагуудад үнэн зөвөөр мэдээллэж шийвэрлүүлэх саналыг цаг тухай бүрт нь уламжилж ажилладаг | 01-12 сар | 100 |
| | **3.2.**Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, хариуг өгөх. | Шийдвэрлэлтийн хувиар | 100% | 50% | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухай бүр амаар болон бичгээр хариу өгч шийдвэрлэлтийг сар бүр ЗДТГэазарт цаасаар болон цахимаар хүргүүлсэн. Хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдол байхгүй. | 01-12 сар | 100 |
| **Зорилт 4. "Төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах"** | | | | | | | |
| 4. | **4.1.**Хугацаатай албан бичиг, тайлан мэдээ, судалгааг бүрэн үнэн зөв гаргаж хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлэх. | Хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд хүргүүлсэн, хувиар | 50% | 100% | 2024 оны 11сарын байдлаар ирсэн баримт бичгийн бүртгэлд87, явсан баримт бичгийн бүртгэлд 69 баримт бичиг бүртгэгдсэн байна. Хугацаатай албан бичиг/29/ ийн хариуг хугацаанд хүргүүлсэн. | 01-12 сар | 100 |
| | | Хугацаатай мэдээ тайланг хугацаанд нь хүргүүлсэн, хувиар | 50% | 100% | Аймаг, сумын ЗДТГазар болон бусад төрийн байгууллага, хувийн хэвшлээс ирсэн судалгаа мэдээ тайланг ирсэн маягт загварын дагуу гарган хугацаанд нь хүргүүлэн ажиллаж хэвшсэн. | 01-12 сар | 100 |
| | **4.2.**Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журам, төрийн | Ашиг сонирхлын болон ёс зүйн | 100% | 100% | Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулиудыг өдөр тутмын ажил, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон үнэнч шударгаар ажиллаж байгаа бөгөөд | 01-12 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, цаг ашиглалт, ажлын бүтээмж, хариуцлагыг дээшлүүлэх. | зөрчилгүй ажилласан байна. | | | ашиг сонирхлын зөрчил үүсгэлгүй албан тушаалын чиг үүргээ шударгаар биелүүлж, иргэд олон нийтээс хууль зөрчсөн ёс зүйн зөрчил үүсгэсэн талаар гомдол санал гараагүй болно. Мөн иргэдээс болон МШУТөвөөр дамжиж гомдол санал ирээгүй. | | |
| | | Ажлын цагийн хоцрогдол, ашиглалтын хувиар | 100% | 100% | Ажлын цаг ашиглалттай холбоотой зөрчил гомдол гаргаагүй бөгөөд шалтгаангүйгээр ажил таслах, хоцрох, ажлын байранд болон ажлын цагаар согтууруулах ундаа хэрэглэх ёс зүйн зөрчил гаргалгүй, ажлын цагийг зөв зохистой ашиглаж, шаардлагатай тохиолдолд илүү цагаар ажилладаг. | 01-12 сар | 100 |
| | **4.3.**Хяналт, шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллах. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | - | 100% | Хяналт, шинжилгээ үнэлгээний дүгнэлт зөвлөмж багийн ажлын албанд ирээгүй байна. | 01-12 сар | 100 |
| | **4.4.**Байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцох. | Хамрагдсан арга хэмжээний тоогоор | 1 | 2 | Байгууллагаас зохион байгуулсан ажил арга хэмжээнд цаг тухай бүр идэвх санаачлагтай оролцсон.<br>1. Гандантүнцоглин хийдтэй хамтран зохион байгуулсан галын их тахилгад багийн 42 иргэнийг хамруулж хамтран ажилласан.<br>2. Монгол бичгийн багц сургалтад хамрагдаж анхан шатны мэдлэг эзэмшиж батламжаа гардан авсан.<br>3. Аймгийн Биеийн тамир спортын газартай хамтран зохион байгуулсан бие бялдрын сорилгод багийн иргэдээ оролцуулж сорилго өгсөн.<br>4. Өсвөрийн бөхийн улсын аварга шалгаруулах барилдаан зохион байгуулагдахад 1 аймаг хариуцаж ажиллалаа.<br>5. Багийн төвийн /1,9,12баг/ нэрэмжит албан | 01-12 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хаагчдын дундах гар бөмбөгийн тэмцээнд оролцсон. | | |
| | **4.5.**Байгууллага, багт туршлага болохуйц шинэлэг ажлыг зохион байгуулах. | Арга хэмжээний тоогоор | 1 | 3 | 1.Багийн иргэдийг цахим орчинд мэдээлэлээр хангах зорилготой цахим хаягын нэрийн хуудас тарааж цахим хаягаа сурталчилсан.<br>2.Багт түр оршин сууж байгаа иргэдэд санамж бичиг тараасан<br>3.Иргэдийн дунд дасгал хөдөлгөөн биеийн тамирыг эрчимжүүлэх хүрээнд спорт заалтай гэрээ хийсэн. | 01-12 сар | 100 |

**Хоёр. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| “Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 2,1.1 | Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлэх | Анхан шатны мэдлэгтэй, үнэмлэхтэй болсон байна | - | 10цаг | Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III, “Хүмүүн бичигтэн хөтөлбөрийн хүрээд долоо хоног бүрийн даваа, лхагва, баасан гарагт үндэсний бичгийн сургалтыг мэргэжлийн багшаас авч, мэдлэг чадвараа дээшлүүлсэн. Энэ удаагийн сургалтаар үндэсний бичгээ сэргээн санах, бататгах, компьютерын хэрэглээний программ дээр бичиж сурах зэрэг хичээлийг үзэж судлан дахин сорил шалгалтыг өгч батламжаа гардан авлаа.Цаашид үндэсний бичгийн мэдлэг чадвараа бататгаж, албан хэрэгцээн дээ нэвтрүүлж, тогтмол хэрэглэж байх зорилт тавин ажиллаж байна. | I-IV улиралд | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2 | Манлайлал, цахим ур чадвараа дээшлүүлэх | Ур чадвар дээшилсэн, чадамжийн үнэмлэхтэй болсон байна. | | 10 цаг | Иргэдэд цахим орчинд хэрхэн соёлтой мэдрэмжтэй хандах гэмт халдлагаас сэргийлэх тухай сургалтыг зохион байгуулсан.<br>Эмэгтэй Төлөөлөгчтэйгөө хамтарч хүүхэд хамгаалалын бодлогын хэрэгжилтийг сургуулиудаар явж шалгасан.<br>Дархан хотод эмэгтэйчүүдийн чуулганд оролцсон. Эмэгтэйчүүдийн манлайлал сургалтанд Илтгэх урлаг сэдвээр 2 цагийн хичээлд сууж мэдлэг чадвараа дээшлүүлсэн. | I-IV улиралд | 100 |

Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.1 | Түр оршин суугчдыг үүрэгжүүлэх зорилготой санамж бичиг бэлдэж тараах | санамж бичиг тараасан иргэний тоо | - | 135иргэн | Багт түр оршин сууж байгаа иргэдийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх зорилготой санамж бичиг бэлдэн тараасан./139/ | 01-12сар | 100 |
| 2.2.2 | Цахим нэрийн хуудас бэлдэж тараах Иргэдийг цахим орчинд мэдээлэл хүлээн авах хандалтыг нэмэгдүүлэх | нэрийн хуудас тараасан иргэний тоо | - | 120иргэн | Багийн FASEBOOK.ЧАТ хаягруу хандах хандалт муу байгаа учир багийн хаягаа сурталчилан таниулах зорилготой Цахим нэрийн хуудас бэлдэж тараасан./120иргэн/ | 01-12сар | 100 |
| 2.2.3 | Иргэдийн дунд дасгал хөдөлгөөн биеийн тамирыг эрчимжүүлэх спортын арга хэмжээ зохион байгуулах | оролцсон иргэний тоо | - | 65 иргэн | Багийн иргэдийн дунд дасгал хөдөлгөөн биеийн тамирыг эрчимжүүлэх зорилгоор 7 хоногийн 1 дэх өдрийн 11-13 цагийн хооронд спорт зааландаа дасгал хөдөлгөөн хийх, софтволебол тоглох зэрэг чөлөөт цагаа өнгөрөөдөг болсон. | 01-12сар | 100 |
| 2.2.4 | Өвс тэжээл тараах, зорилтот өрхөд хүнс барааны тусламж үзүүлэх | тусламж дэмжлэг үзүүлсэн иргэдийн тоо | - | 86 иргэн | Малчин өрхөд хөнгөлөлттэй үнээр 4 удаа өвс тэжээлийг тараасан 64 өрх хамрагдсан. УЗХорооноос 1 малчинд мөнгөн тусламж, ДЗОУБ-с амьжиргааны түвшин доогуур зорилтот 7 малчин өрхөд хүнсний дэмжлэг олгосон. | 01-12сар | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

БАГИЙН ЗАСАГ ДАРГА .............................../ Х.ЦЭРЭНДОЛГОР/ 2024. 11, 25